

(но 0005-088г) дуулжилсан хөснөгийн түүрэлтэй

2

**ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА МОНГОЛ УЛС****Д.Бадарч,Х.Эрдэнэчuluун,**

Хэдийгээр хүн төрөлхтөн нэг дэлхийд амьдарч байгаа боловч тэд баячуудын болон, ядуучуудын гэсэн хоёр өртөнцөд нэгэнт хуваагдан амьдрах болжээ. Үүнтэй холбоотойгоор баян орнууд дэлхийн газар нутгийн 24 хувь, хүн амын 15 хувийг эзэлж нийт баялагийн 56 хувийг эзэмшиж байна. Үүнээс гадуур үлдэж буй хүн амын орлого, амьдралын баталгааг хэрхэн шийдэх асуудалтай холбоотойгоор хөгжлийн тухай яригдах болжээ. Хөгжлийн эцсийн зорилго нь нийт хүн амын ихэнхийг хамарч буй ядуурлыг гэтлэн давах, хүмүүсийн тэгш амьдралыг хангах бололцоог бүрдүүлэх явдал байдаг.

Өнөөдрийн хөгжиж буй орнууд колоничлолоос салж тусгаар улсууд болсноор хөгжлийн асуудал урган гарч ирсэн бөгөөд дээрх орнууд дахь улс төр, эдийн засгийн байдал нь хөгжлийн гэх эдийн засгийн онолыг бий болгоход түлхэц болжээ. Хөгжлийн эдийн засгийн онолыг үндэслэгчид нь 1979 онд Нобелийн шагнал авсан W.Arthur Lewis, (Princeton University). Theodore Schultz (University of Chicago) нар бөгөөд тэд хөгжлийн эдийн засгийн онол нь эдийн засгийн онолын бие даасан салбар гэдгийг баталсан байна.

Энэхүү онолоор уламжлалт эдийн засгийн эдийн онолын судалдаг зүйлээс гадна түүхэн хугацааны хувьд харьцангуй хурднаар өргөн цар хүрээ бүхий хөгжлийг хангахад эдийн засаг, нийгэм, улс төрийн механизм хэрхэн нөлөөлдгүйг судалдаг байна. Хөгжлийн эдийн засгийн онол нь уламжлалт болон улс төр эдийн засгийн онолоос илүү өргөн цар хүрээтэй бөгөөд улс орны хүн амын ихэнхи хэсгийг хөгжүүлэхэд эдийн засаг, соёл, улс төрийн хүрээнд хэрхэн нөлөөлж байгааг илүү ач холбогдол өгдөг байна. Уламжлалт эдийн засгийн онолын маш бага хэсэг нь хөгжлийн эдийн засгийн онолтой тохирч байдаг бөгөөд тэдгээрийг ч бүрэн төгс тохирдог гэж хэлэх бололцоогүй юм. Тухайлбал, хэрэглэгчдийн эрэлт нэмэгдэхэд нийлүүлэлт нэмэгдэх жамтай. Гэтэл хөгжиж буй зарим улс орнуудад ийм тохиолдол ажиглагдаггүй байна.

Ер нь хөгжиж буй улс орнуудын нөхцөл байдал хоорондоо ижил төстэй байж чаддаггүй. Ийм ч учраас хөгжлийн нэг загварын онол байх бололцоогүй юм. Хөгжлийн эдийн засгийн онолын гол зорилго нь хөгжиж буй орнуудыг илүү

сайн ойлгож тэдгээрийн хүн амын амьдралын түвшинг сайжруулахад чиглэдэг бөгөөд доорхи өргөн хүрээтэй асуудлыг судалдаг байна.

1. Хөгжил гэдэг нь бодит утгаараа юу гэсэн үг вэ?
2. Хөгжлийн эх үүсвэр нь юу вэ? Энэхүү хөгжлөөс хэн илүү ашиг олж байна вэ? Яагаад нэг хэсэг ядуу орнууд түргэн хөгжиж, нөгөө хэсэг нь буурай хэвээр үлдэж байна вэ?
3. Буурай хөгжил нь дотоод хүчин зүйл үү, гадаад хүчин зүйл үү?
4. Хөгжик буй орнуудын өнөөгийн нөхцөл байдал нь хөгжингүй улс орнуудын эхэн үетэй ижил төстэй эсэх?
5. Эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг.
6. Хүн амын хурдацтай өсөлт нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж буй?
7. Яагаад хөгжиж улс орнуудад төвд татах хүч эрчимтэй үйлчилж хотжих явц илүү хурдацаж байна вэ?
8. Байгаль орчинтой зохицсон хөгжил гэж юу вэ?
9. Хөгжик буй орнуудын боловсролын тогтолцоо нь эдийн засгийн хөгжилд зэрэгзэр нөлөөлж чадаж байна уу?
10. Либериалчилал өргөжиж байгаа нь ядуу буурай орнуудад ашигтай юу? Үүнээс хэн ашиг олж байна вэ?
11. Хөгжингүй улс орнуудаас үзүүлж буй эдийн засгийн тусамжийн нөлөө ямар байна вэ? Буурай хөгжилтэй орнуудад гадаадын зээл тусамжийг авах хэрэгтэй юу? Авбал ямар нөхцөлтэйгээр авах вэ?
12. Чөлөөт эдийн засаг, өмч хувьчлалын асуудал нь хөгжлийн асуудлыг шийдэж чадах уу?

Энэ бүхнээс үүдэн эдийн засгийн хөгжил гэж юу вэ гэсэн тодорхойлолтын асуудал урган гарч байна.

Урт хугацааны турш эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн чадавхи буюу үндэсний нийт бүтээгдэхүүний өсөлтөөр тодорхойлогдоно гэж үзэж байлаа. Өөрөөр хэлбэл нэг хүнд ногдох орлого буюу нэг хүнд ногдох УНБ өсөж, улс орны орлогын өсөлтийн хэмжээ нь хүн амын өсөлтөөс дээгүүр байхыг харуулж буй үзүүлэлт гол тодорхойлогч нь болж байлаа. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хөгжлийг үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийн бүтцийн өөрчлөлтөөр бас нэг хэсэг тодорхойлжээ. 1960-аад оны үед хөгжиж буй орнуудад эдийн засгийн өсөлт ажиглагдсан боловч хүн амын ихэнхи хэсгийн амьжиргааны түвшин өөрчлөгдөөгүй, харин ч дордсон юм. Үүний гол шалтгаан нь хөгжлийг явцуу хүрээнд тодорхойлсноос болсон гэж үздэг байна. Иймээс 1970-аад оноос ядуурлыг, тэгш бус байдлыг болон ажилгүйдлийг бууруулсан хэмжээгээр хөгжлийг тодорхойлох болсон бөгөөд "Хөгжлөөс дахин хуваарилах" гэсэн нийтлэг ойлголтыг хэрэглэх болжээ. Тухайлбал, 1960- 70-аад оны үед зарим улс орнуудад нэг хүнд ногдох орлогын хэмжээ нилээд хэмжээгээр нэмэгдсэн боловч ажил эрхлэлт, тэгш шударга байдлын үзүүлэлтүүд буурчээ. Эдийн засгийн хөгжлийн анхдагч тодорхойлолтоор дээрх орнууд хөгжсөн гэж харагдах боловч хоёр дахь тодорхойлолтоор ийнхүү хэлэх боломж байхгүй байгаа юм. Энэ байдал 1980-90-ээд онуудад улам ч хурцадсан.

Ер нь эдийн засгийг үнэлэлт үндсэн 3 үнэлэлт байдаг.

Анхдагч үнэлэлт нь анхан шатны хэрэцээгээ хангах чадвартай байх явдал. Хүн бүхэн анхан шатны хэрэгцээтэй байдаг. Төрөөр хэлбэл хүн хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хамгаалалгүйгээр амьдрах арга байхгүй. Хэрэв эдгээр хэрэгцээний аль нэг нь байхгүй буюу маш бага хэмжээгээр хангагдаж байвал тухайн улс орон буурай хөгжилтэй байна гэсэн үг. Эдийн засгийн хамгийн гол үүрэг нь аль болох олон хүнийг хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хамгааллаар хангах явдал бөгөөд энэ бүхэн нь хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулж эцсийн дундээ өөрөө эдийн засгийн хөгжил болж байгаа юм. Өнөөдөр нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн хөгжлийн хангалттай нөхцөл болж чадахгүй байна.

Хоёр дахь үнэлэлт нь хүн өөрийгөө илэрхийлэх чадвартай байх явдал юм. Аливаа нийгэмд хүний амьдралын гол нөхцөл нь өөрийгөө илэрхийлэх чадвар бөгөөд тэр нь нийгэм, соёлтой холбоотойгоор өөр өөр байж болно. Ер нь хөгжих буй ихэнхи улс орнуудын хувьд эдийн засаг болон технологийн арай илүү нийгэмтэй өөрийгөө харьцуулахад өөрийгөө илэрхийлэх чадвар нь угүй болдог байна.

Гурав дахь үнэлэлт нь сонголт хийх чадвартай байх явдал юм. Хөгжлийг илэрхийлэгч гурав дахь хэмжүүр нь хүний эрх чөлөө болдог. Артур Льюс "Эдийн засгийн хөгжлийн давуу тал нь баялаг, аз жаргалыг авчрахдаа бус хүний сонголтын хүрээ нэмэгдсэнд байгаа юм" гэж тэмдэглэсэн байдаг.

Дээр үнэлэлтүүдтэй холбоотойгоор хөгжлийн гурван зорилт урган гарч ирдэг.

Анхдагч зорилт нь амьдралын хэрэгцээ болох хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хамгааллыг сайжруулж, нийгэм дэх хуваарилалтыг тэгш, шударга болгоход оршино.

Хоёр дахь зорилт нь амьжирааны түвшинг нэмэгдүүлэх. Тухайлбал, хүн амын орлогыг өсгөх, ажлын байрыг өсгөх, боловсролын түвшинг дээшлүүлэх. Ингэсээр хүн өөрийг илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэх боломжтой болно.

Гуравдахь зорилт нь хүний эдийн засгийн болон нийгмийн сонголтын хүрээг өргөтгөх. Өөрөөр хэлбэл хүнийг аливаа хамраарлаас ангижруулах явдал юм.

Энэ бүх асуудал нь биднийг өөрийнхөө хөгжлийг эргэн харж, эргэцүүлэн бодоход хүргэж байна.

Манай орны нийгэм эдийн засгийн хөгжил нь байгалийн баялгийн нөөцийн ашиглалтаас өргөн хамааралтай. Байгаль цаг агаараас шууд хамааралтай нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй, байгальд шүтсэн газар тариалан хөдөө аж ахуйд давамгайлж, байгалийн төрөл бүрийн баялгийн нөөцийг /ашигт малтмал, эрдэс түүхий эд зэрэг/ олборлох салбар аж үйлдвэрт зонхилж байна. Улсын нийт экспортын гуравны хоёроос илүү хэсгийг зөвхөн уул уурхайн олборлох чиглэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүн зээлж байна. Үүний зэрэгцээ зөвхөн өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд тариалангийн талбайн 46.5 хувь нь хүчтэй ба дунд зэргийн элэгдэл орж, ойн талбай 1.4 сая га-гаар багасч, бэлчээрийн талбай 6.9 сая га-гаар буурч нийт бэлчээрийн ургамлын зүйл хоёр

дахин цөөрч, нэгж га талбайн хадлангийн ургац 30 орчим хувиар буурсан байна. Хэт талхлагдсан бэлчээрийн ургац бараг 5 дахин багасч, ургамлын зүйл бараг 4 дахин цөөрчээ. Сүүлийн 20 гаруй жилд байгалийн нөхөн сэргээгдэх болон үл сэргээгдэх баялгийн олборлолт, ашиглалт нэлээд өсч, байгаль орчинд үзүүлсэн бөрөг үр дагавар нь ч нэмэгдсэн. Түүнчлэн байгалийн нөөц баялгийг ашигласны улмаас гарсан хатуу болон шингэн хаягдлын хэмжээ хүн амын болон үйлдвэрлэлийн өсөлтөөс илүү хурдацтай нэмэгдсээр байна. Ялангуяа улсын үйлдвэр, аж ахуйн газрыг хувьчилж, олон мянган аж ахуйн нэгж бий болсноор өнөө маргаашийн ашиг хонжоо хайж байгалийн нөөц баялгийг хайр гамгүй ашиглах, нэгэнт ашигласан нөөцөө нөхөн сэргээх үйл ажиллагаагаа орхигдуулах зэрэг зөрчил дутагдал гарсаар байна. Үнд нөөц баялгийг хэн дуртай нь ямар ч үнэ цэнэгүй байгалийн хишиг мэтээр ашиглаж ирсэн урагшгүй практик үйл ажиллагаа ч нөлөөлсөн. Иймд улс орны ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоходоо экосистемийн зохих даацанд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хангах, үр ашгийг нь нэмэгдүүлэх, ард түмний амьжирааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүний уналт 1990 -1993 онд 20 гаруй хувиар буурч, харин 1994 оноос 2.3 хувийн өсөлт гарч эхэлсэн бөгөөд энэ үзүүлэлт 1996 онд 2.4 хувь, 2001 онд 1.1 хувь, 2002 оны урьдчилсан байдлаар 3.8 хувь болохоор байна. 2001 онд инфляцийн түвшин 1996 оныхоос зургаа дахин буурч 8.0 хувьд хүрэв. Гадаад валютын цэвэр нөөц 1996 оныхоос нэмэгдэж импортын барааны 12.6 долоо хоногийн нөөцтэй тэнцэх хэмжээнд хүрлээ. Төсөв, санхүүгийн цэгтэй механизмыг бүрдүүлэх үүднээс улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх дэс дараатай арга хэмжээ авч байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр ихээхэн хязгаарлагдмал байгаа хэдий ч эдийн засгийн төргүүлэх салбар, дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгийн ихэнхийг зарцуулж байна. 2002 онд гадаад худалдааны нийт эргэлт 2001 оныхоос 0.1 хувиар өсч, экспорт 3.9 хувиар буурч, импорт 1.7 хувиар өссөн байна. Нийт экспортын 33.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 27.3 хувийг нэхмэл болон нэхмэлийн бүтээгдэхүүн, 23.8 хувийг алт тус тус зээлж байна. Эдийн засагт уул, уурхай, хөдөө аж ахуйн салбарын зэлэх хувь өндөр хэвээр байна. Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын зэлэх хувь буурсаар байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг үндсэндээ түүхий эдийн чиглэлтэй, экспортод хөдөө аж ахуйн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, уул уурхайн аж үйлдвэрийн түүхий эд гол байр зээлж дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлд өртөмтхий хэвээр байна.

Манай улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад (ДХБ) элсэн орноор гадаад худалдаагаа өргөтгөх, худалдааны салбарыг зах зээлийн нийтлэг жишигт оруулахад чухал алхам болсон. Худалдааны харьцаатай улс орны тоо өсч байгаа хэдий ч худалдааны байнгын тогтвортой түншүүд тэр бүр тодрохгүй байна. Энэ нь бараа, үйлчилгээ, гадаад худалдаа эрхлэгчдийн хөрөнгө, санхүүгийн чадвар сүг байгаатай шууд холбоотой. Импортын бүтцэд өөрчлөлт гарч үйлдвэрлэг техникийн зориулалттай түүхий эд, тоног төхөөрөмжийн импорт (гадаадын зээг тусламж, хөрөнгө оруулалтын чиглэлийн ийм төрлийн бараанаас бусад) багасч өргөн хэрэглээ, хүнсний барааны импорт нэмэгдэв. Цаашдаа хүнс, өргөн

хэрэглээний бараа, цахилгаан эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар импортыг багасгах ихээхэн бололцоотой юм. Гадаад зах зээлд мал аж ахуйн түүхий эдийн эрэлт хэрэгцээ харьцангуй өндөр байгаа боловч мах бэлтгэх технологи хоцрогдсон, анхан шатны боловсруулалт хийгдээгүй, мал эмнэлэг, эрүүл ахуйн олон улсын шаардлагад төдийлөн нийцээгүй байгаа болон сав баглаа боодол, тээвэрлэлтийн нөхцөл доогуур байгаагаас үнэ нь харьцангуй доогуур, зах зээл нь хязгаарлагдмал болж байна. Мал, ялангуяа махны гадаад зах зээл хумигдаж байгаагаас дагалдах бусад түүхий эдийн бэлтгэл дорвитой өсөхгүй байна. Гадаад худалдааг хилийн 20 гаруй боомтоор хийж байгаа ч тэнд чанар, стандарт, ариун цэвэр, ургамлын болон мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын тогтолцоо бүрэлдэж төлөвшөөгүй байна. Экспорт, импортын барааны 90 орчим хувь нь Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүдийн боомтоор дамжих байна. Ингэснээр барааг алс тээвэрлэж, өртөг, зардлыг нь ихээхэн нэмэгдүүлэн гадаад худалдааны үр ашиг, иргэдийн худалдан авах чадварт сергээр нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр дотоодод худалдан авах чадвар дорой байгаагаас худалдаачид үнэ хямдтай, чанарын баталгаагүй бараа импортлож дотоодын хэрэгцээг хангаж байгаа юм. Үүний зэрэгцээ хөдөө орон нутагт үйлдвэрлэл, худалдааны зохистой орчин бүрдээгүйгээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэд байгалийнхаа неец, баялагт үрэлгэн хандаж байгалийн неец, мал аж ахуйн түүхий эдээ гадаадад хямд үнээр борлуулах нөхцлийг бүрдүүлж байна.

1990 оноос хойш манай эдийн засагт бүтцийн өөрчлөлт гарч олон хэв шинжит хосолмол эдийн засгийн харилцаа бүрэлдэж эхэллээ. Терийн өмчийг хувьчилж эхэлснээр эдийн засагт хувийн хэвшлийн эзлэх байр суурь өргөжиж байна. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа нэлээд зугширсан боловч үнэт цаас, хувьцааны арилжааны хоёрдогч зах зээл гүнзгийрч чадаагүй, гүйлгээ, арилжааны үзүүлэлт харьцангуй доогуур байна. Хоёрдогч зах зээл нимгэн, тархай бутархай байгаагаас гадна зуучлалын өртөг харьцангуй өндөр, хувьцааны арилжаа хэдхэн компани дээр төвлөрч байна. Хөрөнгийн бирж нь хөрөнгө оруулагчдыг эрсдэл багатай, түргэн борлогдох чадвар сайтай хөрөнгө оруулалтын хэрэгслээр хангаж чадахгүй байна. Хувьцаа гаргасан компаний талаархи мэдээлэл хомс, тэдний нягтлан бодох бүртгэлийн систем шаардлага хангахгүй, санхүүгийн тайлан мэдээг хөндлөнгийн шалгалтаар баталгаажуулах тогтолцоо хөгжөөгүй зэрэг шалтгааны улмаас олон нийтийн итгэл хүлээж чадахгүй байна. Үнэт цаасанд хөрөнгө оруулахад татварын урамшил бий болгоогүй, үнэт цаасны хөрөнгө оруулалт түүний эрсдэл, өгөөжийн талаар хүмүүсийн мэдлэг боловсрол нимгэн байна. 1997 оны байдлаар нийт хөрөнгө оруулалтын 47 хувь нь дотоод эх үүсвэрээр 53 хувь нь гадаад эх үүсвэрээр санхүүжиж байгаагаас үзэхэд дотоод хуримтлалыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Шинжлэх ухаан, техникийн дэвшилийг тодорхойлогч металл боловсруулах, машины үйлдвэр, электроник, хими зэрэг салбар бараг хөгжөөгүй байна. Орчин үеийн технологийг шилжүүлэн авах гадаад нөхцөл, боломж өргөжих байгаа хэдий ч түүнийг хүлээн авч нутагшуулах дотоодын чадавхи сул байгаагаас эдийн засгийн хөгжилд дорвийт нөлөө үзүүлж чадахгүй байна.

Хөгжлийн үндсэн үзүүлэлтийн хувьд:

#### Тэгш байдлын хувьд

1998 оны Амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээс үзэхэд Монгол улсын хүн амын 35.6 хувь, Улаанбаатар хотын хүн амын 34.1 хувь хөдөөгийн хүн амын 32.6 хувь нь ядууралд хамрагдаж, 1995 оны хамрагдалтын түвшингээс 0.5-1.0 пунктээр буурсан байна.

Ядуу хүн амын хамрагдалтын хүрээ Улаанбаатар хотод 1995 оноос буурсан байхад хот, суурин газрынх 1998 онд өндөр хэвээр байгаа нь аймгийн төвд ядууралд яхьгаатай холбоотой. Үүний гол шалтгаан нь аймгийн төвд ажилгүйдэл харьцангуй өндөр байгаа явдал юм.

Хэрэглээний (орлогын) тэнцүү биш хуваарилалтыг илэрхийлдэг Gin коеффициент нь 1995 онд 0.31 байснаа 1998 онд 0.35 болж өссөн нь хэрэглээний/орлогын тэгш бус байдал нэмэгдсэнгийг илэрхийлж байна.

#### Ажил эрхлэлтийн хувьд

Улсын хэмжээгээр 2000 оны эцэст ажиллах хүчиний оролцооны түвшин 62.9 хувь, ажил эрхлэлтийн хувь 60.0 хувь, ажилгүйдлийн түвшин 4.6 хувь байгаагийн дотор эмэгтэйчүүдийн ажиллах хүчиний оролцооны түвшин 61.0 хувь ажил эрхлэлтийн хувь 58.0 хувь, ажилгүйдлийн түвшин 5.0 хувь байна. Нийт ажилгүйчүүдийн талаас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

#### Дундаж наслалтын хувьд

Монгол хүний дундаж наслалт 1998 оны тооцоогоор 65.1 байна. Харин хүйсийн ялгаатай авч үзвэл эмэгтэй хүний дундаж наслалт 67.6, эрэгтэйнх 62.7 байна. Сүүлийн 10 жилийн тоо баримтаас үзэхэд Монгол хүний дундаж наслалтын хугацаа 1-2 жилээр уртассан байна.

#### Насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлгадлын хувьд

Монгол улс нь хүн амын бичиг үсгийн мэдлэг өндөртэй орон юм. 2000 оны хүн амын тооцоогоор Монгол улсын 15 болон түүнээс дээш насын хүн амын 97.8 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй байгаагийн дотор эрэгтэй хүн амын 98 хувь, эмэгтэй хүн амын 97.5 хувь бичиг үсэг тайлгадсан байна.

#### Хүн амын өсөлтийн хувь

Хүн амын тоо 2000 оны эхэнд 2373.5 мянга болж, өмнөх 1989 оны тооцоогоос хойш 16.1 хувиар буюу жилдээ дунджаар 1.4 хувиар өсчээ. Сүүлийн 11 жилд хүн амын өсөлт саарсан нь хүн амын өсөлт буурч, гадаад шилжүй хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой.

#### Хуулиар болон хууль бусаар суурьшсан хотын хүн ам

Сүүлийн хоёр, гурван жилд Монгол улс улам бүр хотжих шинж чанартай болж, хотжилт нэмэгдсээр байна. Бусад улс орны нэг адил Монгол Улс хөдөө аж ахуйгаас үйлдвэржилт рүү шилжих үйл явцын улмаас нийслэл хот болох бусад томоохон хот, суурин газар өргөжих байгаа нь хүн амын суурьшилтанд хүчтэй нөлөө үзүүлэв. Эдгээр хот, суурин газар нь эрүүл мэнд, боловсрол болох бусад үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр бий болгох төв болж, бусад газраас хүмүүсийг татах хотжилтын үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1345 мянган хүн хотод, өөрөөт хөлбэл нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн төв, 22 тосгонд амьдарч байна.

Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод аймгуудын хүн амын талаас илүү хувь нь хотод амьдарч байна. 40000-с дээш хүн амтай дөрвөн хотод 2000 оны байдлаар нийтдээ 936 мянган хүн буюу нийт хүн амын 39 хувь нь амьдарч байна. Энд Улаанбаатар (760 мянга), Эрдэнэт (68 мянга), Дархан (66 мянга), Чойбалсан (42 мянга) орж байна.

**Нэг хүнд ногдох ДНБ**

Энэ үзүүлэлт нь улс орны эдийн засгийн хөгжлийг харуулах гол үзүүлэлт юм. Дэлхийн Банкны атласын аргаар тооцсон Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1999 онд 390 ам доллар байна.

**ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувь**

2000 онд ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтцэд хөрөнгө оруулалтын эзлэх хувь 23.6 хувь байгаа нь 1995 онтой харьцуулахад харьцангуй өссөн байна. Хөрөнгө оруулалт нэмэгдэх нь үйлдвэрлэл, үйлчилгээ өсөх, дэд бүтэц сайжрах боломжийг бүрдүүлнэ.

**Өр/ҮНБ-ний харьцаа**

Гадаад өр ҮНБ-ий харьцаа нь тухайн орны өрийг төлөх чадварыг харуулна. Гадаадын зээлийн хэт их өсөлт нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг. Үүний тулд өрийн дарамт буюу өр ҮНБ-ий харьцааг авч үздэг. Гадаадын зээл ДНБ-ий 60 хувиас хэтэрвэл улс төр, эдийн засгийн хувьд хараат байдалд орох аюултай талаар судлаачид тэмдэглэсэн байдаг. Манай улсын гадаад өр 1999 оноос хойш мэдэгдэхүйц өсч ОУВС-аас тогтоосон босго утгаас ихээхэн хэмжээгээр давсан байна. Иймд гадаад өрийн атлаар төрийн цэгцтэй бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

**Авсан хөгжлийн албан ёсны нийт тусlamжийн ҮНБ-д эзлэх хувь**

Манай гол хандивлагч орон Япон улсын Засгийн газраас Дэлхийн Банктай хамтран жил бүр хандивлагчдын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж Монгол улсад үзүүлэх зээл, тусlamжийн асуудлыг шийдвэрлэж байна.

Нэг хүнд ногдох зээл, тусlamжийн хэмжээ 1999 онд 92 доллар байсан байна. 2000 оны байдлаар Монгол улсын авсан хөгжлийн албан ёсны тусlamжийн ҮНБ-д эзлэх хувь 17.1 байна.

**Бараа үйлчилгээний худалдааны тэнцилийн хувьд**

Манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ сүүлийн жиүүдэд тасралтгүй унасан, импортын татварыг тэглэснээс шалтгаалан манай гадаад худалдааны нөхцөл ихээхэн доройтож, гадаад худалдааны алдагдлын ДНБ-д эзлэх хувь 1998, 1999 онд 11.5-11.8 хувьд хүрч нэмэгдсэн юм. Гадаад худалдааны алдагдал өсөхөд түүний бүтцийн хоцрогдол нөлөөлсөөр байна. Энэ нь манай экспортод уул уурхай, эрдэс бүтээгдэхүүн, мал аж ахуй, түүхий эд голлож, эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувь төдийлөн нэмэгдэхгүй байгаагаар илэрч байна. Гэтэл дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ ихэвчлэн унаж, харин импортоор авдаг эцсийн бүтээгдэхүүний үнэ өссөөр байна.

Энэхүү үзүүлэлтүүд нь Монгол улсын хөгжлийг тодорхойлж байгаа бөгөөд түүнийг өсгөх, хөгжүүлэх арга замыг тодорхойлох нь судлаач та бидний үүрэг билээ.